



ХЭНГИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 6 сарын 5 өдөр

Дугаар А/101

Чингис хот

Цалин нэмэх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 99 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам”-ын 136.4.2-ын “в” заалт, 136.5.2-ын “г” заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар батлагдсан “Алба хаагчийн ажлыг үнэлэх /код 111/ журам”-ын 111.4 дэх заалт, Цагдаагийн газрын даргын зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2017 оны 05 дугаар сард ажлын байрны тодорхойлолтонд заасан чиг үүрэгт ажилдаа идэвхи санаачлага, үр дүн гаргаж ажилласан 68 алба хаагчдын албан тушаалын үндсэн цалинг нэмж, хавсралтаар баталсугай.
2. Хавсралтад заагдсан 68 алба хаагчдын албан тушаалын үндсэн цалинг заасан хувиар нэмж бодож олгохыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн хошууч Т.Чинбаатарт даалгасугай.
4. Тушаалын хуулбарыг хувийн хэрэгт нь хавсаргахыг Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад П.Алтантуяад үүрэг болгосугай.
5. Тушаалыг нийт бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.ГАНБАТ